



Агуулга

Монгол Улс бол далайд гарцгүй хоёр дахь том орон бөгөөд байгалийн асар их нөөц баялагтай. Дундад зууны үеийг хамарсан баялаг, бахархам түүхтэй Монгол Улсын орчин үе нь ЗХУ задран унасны дараа 1990-ээд оны эхээр зах зээлийн эдийн засагт шилжсэнээр эхэлсэн гэж тэмдэглэгдсэн байдаг.

Одоогийн байдлаар Монгол Улсын эдийн засгийн үндсэн хоёр салбар нь хөдөө аж ахуй, уул уурхай юм. Монгол Улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гол хурдасгуур нь энэ хоёр салбар болсон. Гадаадын хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ Монгол Улсад үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүссэн. Монгол Улсын уул уурхайн салбарт үндэстэн дамнасан компаниуд зонхилдог бөгөөд тус салбар нь 2019 онд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 19 хувь, экспортын үнийн дүнгийн 94 хувийг бүрдүүлж байв.¹ Гэхдээ улсын төсөвт тэр хэмжээгээр зохих хувь нэмрийг оруулаагүй байна. Үүний үндсэн хоёр шалтгаан нь зарим үндэстэн дамнасан уул уурхайн компаниудын Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэх (BEPS)² стратеги, болон татвар төлөгчийн энэхүү үйлдлийг олж илрүүлэх, шийдвэрлэх туршлага ур чадвартай хүний нөөц Монголын татварын албанд хязгаарлагдмал байна. Иймд Монгол Улсын татварын алба олон улсын түншүүдтэй энэ чиглэлээр хамтран ажиллах хүсэлт гаргасан.

Монгол Улс эрдэс баялгийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлд⁴ нарийвчилсан үнэлгээг хийсэн Уул уурхай, ашигт малтмал, металл ба тогтвортой хөгжлийн асуудлаарх Засгийн газар хоорондын форум (ЗГХФ)³-д 2015 онд гишүүнээр элссэн. Монгол Улс 2017 онд Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхийн талаарх ЭЗХАХБ/Их 20-ын санаачлагад нэгдэн орсон бөгөөд 2018 онд хууль эрх зүйн зохицуулалтаа шинэчлэх, татварын нарийн төвөгтэй төлөвлөлт, болон схемтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх, татварын зорилгоор мэдээлэл солилцож (EOI), ил тод байдлыг хангах олон улсын стандартыг хэрэгжүүлэх (Нэмэлт мэдээлэл 2) үүрэг

хүлээж Глобал форум-д элсэн орсон. Улмаар 2019 оны эхээр Монгол Улс ЭЗХАХБ болон ЗГХФ-д уул уурхайн салбарт татвар ногдуулах техник туслалцааны хөтөлбөр хэрэгжүүлэх хүсэлт гаргаж (Нэмэлт мэдээлэл 1), ЭЗХАХБ болон ЗГХФ нь Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөр (TIWB)⁶, 'Уул уурхайн салбарт Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхийн талаарх Deep Dive' хөтөлбөрүүдийг Монголд 2019 оны сүүл гэхэд эхлүүлсэн.

“**Монгол Улсын Татварын албаны хувьд 2019 он нь үйл явдлаар дүүрэн жил байлаа. Тухайлбал татварын багц хуулиуд шинэчлэн батлагдсан, татварын албаны мэдээллийн системийн шинэчлэлт, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлсэн зэргийг дурдаж болно. Татварын алба нь татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхийн эсрэг ЭЗХАХБ/Их 20-ын санаачлагад болон Глобал форумд нэгдэн орж, улмаар ЗГХФ-ЭЗХАХБ-ийн “Уул уурхайн салбарт Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхийн талаарх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, татвараас зайлсхийх асуудлыг шийдвэрлэх, дотоодын орлогыг төвлөрүүлэх, татварын албаны албан хаагчдыг чадавхжуулах зэргээр хөтөлбөрийн үр ашгийг хүртэх, олон улсын хамтын ажиллагааг дэмжих тал дээр онцгой анхаарсан.**”

Монгол улсын Татварын Ерөнхий газрын дарга
Батжаргалын Заяабал

Монгол Улс 228 сая ам.долларын нөхөн татвар ногдуулж, 1.5 тэрбум ам.доллараар ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлын дүнг бууруулж, уул уурхайн салбарт үүссэн татварын зөрүүг багасгасан.

Монгол Улс нь уул уурхайн салбар дахь татварын зөрүүг багасгалаа

“Уул уурхайн салбарт Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхийн талаарх Deer Dive”, Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөрүүд хэрэгжиж эхлээд 14 сарын дараа Монгол Улсын Татварын алба үндэстэн дамнасан томоохон уул уурхайн компанид иж бүрэн татварын хяналт шалгалт хийх явцад анхны үнэ шилжилтийн^{7,8} тохируулга хийж **228 сая ам. долларын нөхөн татвар ногдуулж, 1.5 тэрбум ам.доллараар ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлын дүнг бууруулсан**. Энэхүү ногдуулалтын дийлэнх хувь нь 2019 оны аравдугаар сард байгуулагдсан үнэ шилжилтийн хэлтсийн ажлын үр дүн байсан бөгөөд асуудал бүрэн шийдэгдээгүй байгаа ч татвар төлөгч 228 сая ам.долларын татварын ногдуулалтыг бүрэн төлснийг дурдах нь зүйтэй юм. Энэ нь Монголын Татварын алба болон ЭЗХАХБ-ын хамтын ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгжиж байгаа Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөрийн үр дүнтэй түншлэл, Татварын албаны өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл, чадварлаг байцаагчдын тууштай хамтын ажиллагааны үр дүн байлаа.

“ Үнэ шилжилтийн хяналт, шалгалтыг Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөр, ЗГХФ, ЭЗХАХБ-ийн мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар хийсэн нь Монголын Татварын албаны хувьд томоохон ахиц дэвшил боллоо. Хяналт шалгалтын үр дүн нь татварын байцаагчдын чадавх, түүнчлэн татвараас зайлсхийх асуудалтай тэмцэж буй олон улсын хамтын хүчин чармайлтын илэрхийлэл юм. Энэхүү хяналт, шалгалтын кэйс нь Монгол Улсын татварын тогтолцоог хөгжүүлэх, татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх чухал үйл явдал юм. ”


Монгол улсын Татварын Ерөнхий газрын дарга
Батжаргалын Заяабал

Нэмэлт мэдээлэл 1: Уул уурхайн салбарын татвар ногдуулалтын техник туслалцааг сайжруулах нь

Хөгжиж буй олон орны хувьд уул уурхайн салбараас олсон орлого нь эдийн засгаа өсгөх, төрийн чухал үйлчилгээг санхүүжүүлэх томоохон боломжийг олгодог. Тиймээс засгийн газрууд уул уурхайн татварын тогтолцоог бий болгох, удирдах мэдлэг, ур чадвар, арга хэрэгсэлтэй байх нь туйлын чухал юм.

ЭЗХАХБ болон ЗГХФ нь хөгжиж буй орнуудад уул уурхайн салбар дахь татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд туслах зорилгоор 2017 оноос хойш хамтран ажиллаж байна. Энэ нь ЗГХФ-ийн уул уурхайн туршлага, ЭЗХАХБ-ийн олборлох салбартай холбоотой олон улсын татварын талаарх мэдлэгийг хослуулсан өвөрмөц түншлэл юм. Энэхүү хамтарсан хөтөлбөр нь улс орнуудад уул уурхайн болон олон улсын татварын хууль тогтоомжийг шударгаар хэрэгжүүлэх замаар улмаар байгалийн баялгын үр өгөөжийг шударгаар хүртээхэд чиглэгдсэн. Түүнчлэн уул уурхайн салбарт ногдуулах татварын орлогыг хамгаалах хууль тогтоомж, бодлого боловсруулах талаар туслалцаа үзүүлдэг.

ЭЗХАХБ/ЗГХФ-ийн “Уул уурхайн салбарт Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхийн талаарх Deer Dive” хөтөлбөр нь 2-3 жилийн хугацаатай техникийн туслалцааны урт хугацааны хөтөлбөрийн хүрээнд сургалт, хууль эрх зүй, татварын бодлогын зөвлөх үйлчилгээ, татварын хяналт шалгалтад бодит-практик дэмжлэг үзүүлэх зэргээр татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэх явдалтай тэмцэх тусгайлсан удирдамж, чиглэлээр хангаж, чадавхийг бэхжүүлж ажилладаг. Хөтөлбөрийн үр ашгийг хүртэгчид нь Африкийн зарим улс орнууд, Ази, Номхон далай, Латин Америкийн сонгогдсон орнууд юм.



Уул уурхайн салбарын татварын хяналт шалгалтад мэргэжилтнүүдийн үзүүлсэн бодитой тусламж, дэмжлэг

Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөр нь ЭЗХАХБ болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн хамтарсан санаачилга бөгөөд хөгжиж буй орнуудын татварын албаны хяналт, шалгалтын байцаагчдын чадавхийг “Ажил дээр хийж байж л сур” гэсэн арга барилаар сайжруулах зорилготой юм. Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөр нь 2015⁹ онд байгуулагдсан цагаасаа хойш олон улсын татварын хяналт, шалгалтын чадавхийг бэхжүүлэхэд голлон анхаарч ирсэн. Гэхдээ уул уурхай зэрэг нарийн төвөгтэй салбаруудад хяналт шалгалт хийх нь салбарын онцлогийг татварын ашиг хүртэх зорилготой төлөвлөлт, схемээс ялгаж салгаж ойлгох тусгай мэдлэгийг шаарддаг хүндрэлтэй байдаг. ЭЗХАХБ/ЗГХФ-ийн “Уул уурхайн салбарт Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхийн талаарх Deep Dive” хөтөлбөртэй хамтран ажиллах нь Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөрийн мэргэжилтнүүдийн үнэ шилжилтийн хяналт шалгалтын туршлагыг ЭЗХАХБ болон ЗГХФ-ийн уул уурхайн мэргэжилтнүүдтэй хослуулах ховор боломжийг олгодог. Энэ шинэлэг арга нь байгалийн баялаг ихтэй хөгжиж буй орнуудын олборлох салбар дахь татвараас зайлсхийх үйлдэлтэй тэмцэх цогц шийдэлд хүрэх эрэлт хэрэгцээг үр дүнтэйгээр хангах боломжийг ЭЗХАХБ, ЗГХФ, Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөрийн холбогдох хөтөлбөрүүдэд олгодог.

- **Татварын ерөнхий газарт Үнэ шилжилтийн хэлтсийг шинээр байгуулав:** 2019 оны 10 дугаар сард Татварын ерөнхий газраас Үндэстэн дамнасан компаниудын харилцан хамааралтай этгээдтэй хийсэн гүйлгээнд баримтлах татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Үнэ шилжилтийн хэлтсийг байгуулав. Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхтэй тэмцэх төслийн хүрээнд Татварын ерөнхий хуульд орсон үнэ шилжилтийн зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд Татварын алба онцгой анхаарч ажиллав. Үнэ шилжилтийн хэлтэс байгуулах зөвлөмжийг цаг алдалгүй хэрэгжүүлэх нь Монгол Улсын Татварын албаны хувьд

үнэ шилжилтийн зөрчлийг илрүүлж, олборлох салбар дахь их хэмжээний татварын ногдуулалт хийхэд чухал ач холбогдолтой байсан.

- **Дэлхийд тэргүүлэгч мэдээллийн санг худалдан авах, үнэ шилжилтийн жишиг үнэ тогтоох бодитой-практик туршлага эзэмших:** 2019 оны сүүлээр ЭЗХАХБ-аас Монгол Улсын Татварын ерөнхий газарт үнэ шилжилтийн жишиг үнийг тогтооход ашиглаж болох мэдээллийн сангийн сонголтууд болон туршилтыг үнэлгээний процесст энэхүү мэдээллийн санг ашиглахыг зөвлөсөн. Бичгээр өгсөн зөвлөгөө болон **бодит-практик** туршлагауд нь ТЕГ-т санхүүгийн нөөцөө хамгийн тохиромжтой мэдээллийн санд зарцуулах шийдвэрийг гаргахад дэмжлэг болсон. Татварын ерөнхий газрын энэхүү шийдвэр нь үнэ шилжилтийн зорилгоор бодит үнэ тогтоох, жишиг үнийн мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлсэн.
- **Дотоодын татварын хууль, уул уурхайн гэрээ, олон улсын эрх зүйн зохицуулалтуудын үйлчлэлийг үнэлэх, дүгнэх чадавхийг эзэмших:** ЗГХФ нь 2020 онд Татварын ерөнхий газрын холбогдох албан хаагчдад уул уурхайн гэрээнд дүн шинжилгээ хийх, гэрээний заалтыг хэрэглэх, тайлбарлах чадавхийг сайжруулах ажлыг гүйцэтгэсэн. Уул уурхайн гэрээ гэдэг нь Засгийн газар болон уул уурхайн салбарт хөрөнгө оруулагч нарын хооронд байгуулсан хууль ёсны гэрээ юм. Энэ нь ихэвчлэн засгийн газар нь хөрөнгө оруулагчдад хамаарах татварын хуулийг өөрчлөх боломжийг хязгаарлах зорилгоор татварыг тогтворжуулах зохицуулалтыг агуулдаг. Чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд хөрөнгө оруулалтын гэрээ, дотоодын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн уялдаа холбоог ойлгоход тусалсан бөгөөд цаашид Монгол Улсад хийгдэх уул уурхайн гэрээ хэлэлцээр болон давтан хэлэлцээрүүдэд мэдээлэл болно.

Ололт амжилтад тулгуурлан, татварын эрх зүйн орчинг сайжруулах

Татварын хяналт шалгалт нь татварын хууль тогтоомжийн хэрэглээнээс ихээхэн хамаардаг. Хөгжиж буй орнуудын хувьд уул уурхай зэрэг эдийн засгийн чухал салбарын харилцааг дотоодын болон олон улсын татварын хууль тогтоомжоор маш сайн зохицуулсан байхыг шаарддаг.

Татварын зорилгоор мэдээлэл солилцож (EOI), ил тод байдлыг хангах олон улсын стандартыг хэрэгжүүлэх

Татварын зорилгоор мэдээлэл солилцож (EOI), ил тод байдлыг хангах нь гол хэрэгслүүдийн нэг бөгөөд татварын албаны хяналт шалгалт хийх эрсдэлийн үнэлгээг тооцох

чухал шаардлагатай мэдээллийг олж авах боломжийг олгодог.

Монгол Улс нь Глобал форумын гишүүн орны хувьд татварын ил тод байдлын стандартыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд Глобал форумаас Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хамтран хэрэгжүүлж буй татварын албаны чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрт Монгол Улс мэдээлэл харилцан солилцох эрх зүйн болон бодит нөхцөлийг бүрдүүлэх, дотоодын нөөцийг дайчлах чиглэлээр дэмжлэг, туслалцаа авч хамтран ажиллаж байна.



Үнэ шилжилтийн орчин үеийн зарчим

ЭЗХАХБ нь 2019 онд Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэх болон Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ олон улсын татварын эрх зүйн орчинг шинэчлэх чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллаж, татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэх арга хэмжээний зарим гол зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Монгол улсад 2020 оноос өмнө харилцан хамааралтай этгээдүүдийн хооронд хийсэн ажил гүйлгээг Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Татварын ерөнхий хууль гэсэн гурван хуулиар зохицуулсан байсан. Эдгээр хууль тогтоомжид өөр өөрөөр зааснаас үүдэн татварын алба болон татварын байцаагчдад хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан.

Шинэчлэн батлагдсан татварын ерөнхий хуулийн хүрээнд үнэ шилжилтийн үндсэн зарчим болон бусад харилцааг нэгтгэн тусгаж, үнэ шилжилтийн харилцааг зохицуулсан журам болон харилцан хамааралтай этгээдтэй хийсэн гүйлгээг баримтжуулж тайлагнах, тайлангийн загварыг батлуулан мөрдөж байна.

Татварын эрх зүйн орчны энэхүү томоохон өөрчлөлтийг ЭЗХАХБ-аас үзүүлсэн орчин үеийн татварын тогтолцоог удирдах чиг хандлагад нийцсэн зөвлөмж туслалцааны дэмжлэгтэйгээр хийсэн.

Хөрөнгийн орлогод ногдуулах татварыг бүрэн ногдуулах зорилгоор ашигт малтмалын лицензийг үнэлэх нь

ЭЗХАХБ болон ЗГХФ-аас техникийн зөвлөгөө авч Татварын албаны чадавхийг бэхжүүлснээр Монгол Улс хөрөнгийн орлогод татвар ногдуулах зорилготойгоор шинэ зохицуулалтыг нэвтрүүлж чадсан. Өмнө нь ашигт малтмалын лиценз эзэмшигч компаниуд Монгол Улсад хамгийн бага татвар төлөх аргыг сонгох боломжтой байсан. Шинэчлэн батлагдсан хуулиар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний аргуудыг тодорхойлж, татвараас зайлсхийх боломжийг хязгаарлах, Монгол Улсын татварын

суурийг хамгаалах боломжийг бий болгосон. Энэ нь хөрөнгө оруулагчдад ч мөн хөрөнгийн орлогод татвар ногдуулах, тооцох үнэлгээний аргуудыг тодорхой болгож өгсөн.

Татварын орлогыг хойшлуулахаас сэргийлсэн ашигт малтмалын лиценз бүрээр тайлагнах аргыг нэвтрүүлсэн (ring-fencing)

Монгол Улсад олон төсөл хэрэгжүүлж буй уул уурхайн компаниуд хайгуулын болон эхний шатандаа яваа төслийн алдагдлыг дуусах шатандаа яваа, орлого олдог олборлолт, үйлдвэрлэлийн татвар ногдох ашгаас нөхөхөөс сэргийлсэн тусгаарлах буюу "ring-fencing" хийх аргыг шинэчлэн батлагдсан татварын хуульд оруулсан. Төслүүдийн орлого зардлыг нэгтгэн тайлагнаснаар компанийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөлтийг хойшлуулах боломжтой болдог. ЭЗХАХБ болон ЗГХФ нь лиценз бүрээр тайлагнах шинэ журмын төслийг боловсруулах чиглэлээр туслалцаа үзүүлж, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх чиглэлд ажиллаж байна. Энэ журам нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг зохиомлоор хойшлуулахаас сэргийлж, татвар хураалтын хугацааг урагшлуулж, Монгол Улсад татварын орлогыг хугацаанд нь төвлөрүүлэх, татварын орлогыг төлөвлөхөд хялбар болгоно.



ЭЗХАХБ болон ЗГХФ-ийн Уул уурхайн салбарт Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхийн талаарх Deep Dive хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээ, Монгол улс, Улаанбаатар хот (2019 оны 8-р сар).

Нэмэлт мэдээлэл 2: Татвараас зугтах, зайлсхийх явдалтай тэмцэх зорилгоор мэдээлэл харилцан солилцох сувгийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх чиглэлээр

- Монгол Улс мэдээлэл харилцан солилцох стандартыг хэрэгжүүлэхийн тулд хууль эрх зүйн томоохон шинэчлэл хийсэн бөгөөд үүнд:
- Татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох ажлын хүрээнд банкны мэдээллийг авах;
- Мэдээлэл харилцан солилцох хүсэлтийн дагуу Татварын алба нь мэдээлэл авах эрхтэй байна;
- Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг шинэчилж, бүх хуулийн этгээдүүд өөрийн эцсийн өмчлөгчийг Улсын бүртгэлийн газарт мэдээлэх үүрэгтэй болсон.

Монгол Улс 2019 оны арван нэгдүгээр сард Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенц (МААС)¹⁰ -д гарын үсэг зурж, 2020 оны зургаа дугаар сард хэрэгжиж эхэлсэн. МААС нь олон улсад татвараас зугтах, зайлсхийхтэй тэмцэх зорилгоор татварын асуудлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах олон улсын эрх зүйн орчныг бүрдүүлдэг олон талт гэрээ юм. Монгол Улс МААС-д элссэнээр татварын асуудлаар хамтын ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлж, 140 гаруй улстай хамтран ажиллах нөхцөл бүрдсэн.





Сургамж

Олборлох салбар нь эдийн засгийн томоохон өсөлтийг бий болгож, хөгжиж буй орнуудын төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой. Зарим хөгжиж буй орнуудад олборлох салбарт татвараас зайлсхийх байдал их байгаа ба Монгол улсад ч төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд хүндрэл үүсэж байна. ЭЗХАХБ, ЗГХФ, Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөрийн олборлох салбарт хийж буй ажил нь бусад байгалийн баялаг ихтэй хөгжиж буй орнуудад ч мөн ижил байна. 2015 оноос хойш ЭЗХАХБ болон ЗГХФ нь байгалийн баялаг ихтэй хөгжиж буй 37 гаруй оронд туслалцаа үзүүлж, таван идэвхтэй “Deep-Dive” хөтөлбөрийг эхлүүлээд байна.

Монгол улсад хэрэгжүүлсэн хөтөлбөрийн туршлагаас хархад чадавхийг бэхжүүлэх илүү оновчтой ойлголтыг олж авсан. Үүнд:

1. Чадавхийг бэхжүүлэх урт хугацааны хөрөнгө оруулалт хийх

– Хууль мөрдөлтийг сайжруулах санал санаачилгыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн болон салбарын мэдлэгийг хөгжүүлэхэд татварын албаны ажилтнуудаас нилээд цаг хугацаа шаардагдсан. ЭЗХАХБ, ЗГХФ, Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөр, Глобал Форум, АХБ нь Монголын татварын ажилтнуудын чадавхийг дээшлүүлэхэд урт хугацаанд тусалж, дэмжиж ирсэн. Улмаар Монгол Улсын эрх бүхий албан тушаалтнууд уг хөгжлийн хөтөлбөрт шаардлагатай зохих мэдлэг, ур чадвар бүхий боловсон хүчнээр хангаж, санаачлагыг дэмжиж ажилласан. Мөн Олон улсын валютын сан, Дэлхийн банк групп, Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг болон бусад хөгжлийн түнш байгууллагууд нь татварын албаны бүтэц болон хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Татварын албанд тусалж, чухал үүрэг гүйцэтгэсэн.

2. Олон талт, харилцан дэмжлэг бүхий техник туслалцаа – ЭЗХАХБ, ЗГХФ, ХИЛ ХЯЗГААРГҮЙ ТАТВАРЫН БАЙЦААГЧИД ХӨТӨЛБӨР, Глобал форум, АХБ нь хууль эрх зүйн болон бодлогын хосолсон шинэчлэл, түүнчлэн Татварын тогтолцоог боловсронгуй болгох замаар тулгамдаж байгаа татварын хууль тогтоомжийн хийдлийг арилгахад харилцан туршлага солилцож ажилласан. ЭЗХАХБ, ЗГХФ, Глобал форум,

АХБ нь Сангийн яам, Татварын ерөнхий газартай хамтран хууль эрх зүйн орчны шинэчлэл дээр ажилласан бол Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөр нь татварын улсын байцаагчид татварын хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхийг бэхжүүлэх чиглэлд шаардлагатай мэдлэг чадавхийг олгох чиглэлээр ажилласан. Энэ нь татвараас зугтах, зайлсхийх явдалтай тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг Сангийн яам, Татварын ерөнхий газар, Хууль зүйн яам зэрэг төрийн байгууллагууд харилцан уялдаатай ажиллахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

3. Уул уурхайн салбарыг тусгайлан авч үзэх нь – уул уурхайн салбар нь эдийн засгийн баялгийг орон нутагт хуваарилах боломжийг бүрдүүлдэг. 2019 оны байдлаар хөгжиж буй 41 орны дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 20 гаруй хувийг, хөгжиж буй 13 орны ДНБ-ий 10 гаруй хувийг бүрдүүлдэг энэхүү салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл их байдаг. Олборлох үйлдвэрийн салбарт татварын хууль тогтоомж мөрдөлтийг сайжруулах санаачилга гаргаж, татварын зохистой бодлогыг тодорхойлоход тухайн салбар, татварын бодлого, татварыг хууль мөрдөлтийн талаарх мэдлэгийг хослуулах шаардлагатай байдаг. Өргөн хүрээний энэхүү техник туслалцааг ганц байгууллага дангаараа үзүүлж чадах нь тун ховор юм. ЭЗХАХБ, ЗГХФ, Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөрүүд маш амжилттай хамтран ажилласнаар техникийн туслалцааны чанарыг сайжруулах, давхардлыг арилгах зэрэг өндөр үр дүнтэй болохыг харуулж байна.

4. Төрийн байгууллагуудын найрсаг хандлага

– Татварын ерөнхий газрын уул уурхайн салбарт үнэ шилжилтийн хяналт шалгалтыг амжилттай явуулахад мэдлэг чадвар олгох чиглэлээр ажиллахад төрийн эрх бүхий албан тушаалтнууд ихээхэн дэмжлэг үзүүлж ажилласан. Мэргэжилтнүүдийн өгсөн зөвлөмжүүдэд уян хатан, шуурхай хандаж, Монголын анхны үнэ шилжилтийн хяналт шалгалтыг явуулах ур чадвар бүхий татварын улсын байцаагчдаас бүрдсэн багийг шуурхай бүрдүүлж, хөтөлбөрийн туршид эрч хүчтэйгээр манлайлж, татварын хяналт шалгалтыг удирдлага чиглэлээр хангаж, шийдвэртэй бодлого гаргаж, зохион байгуулалтын шинэчлэлийг хэрэгжүүлсэн.

Цаашид хийгдэх ажил



Монгол Улсын анхны үнэ шилжилтийн хяналт шалгалт амжилттай болсон нь Татварын ерөнхий газрын дарга уул уурхайн салбарын үнэ шилжилтийн хууль мөрдөлтөд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллахад нөлөөлсөн. Үүний тулд Хил хязгааргүй татварын байцаагчид хөтөлбөр нь Монгол улсыг цаашид дэмжих хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлж ажиллахаа илэрхийлж, 2021 онд хоёр шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон. Үүний нэгэн адил ЭЗХАХБ болон ЗГХФ нь үнэ шилжилтийн мэдлэг чадавхийг сайжруулах чиглэлээр Том татвар төлөгчдийн газар болон дүүргийн татварын хэлтсүүдийг хамруулан өргөжүүлэхийг дэмжиж байна. Үүнд татварын хяналт шалгалтын байцаагчдыг Монгол Улсын шинэчлэн батлагдсан татварын хуулийн үнэ шилжилтийн хууль тогтоомжийн хэрэглээ, эрсдэлийг илрүүлэх, өндөр эрсдэл бүхий гадаад харилцан хамааралтай этгээдтэй хийсэн гүйлгээг тодорхойлох мэдээллийн шинжилгээний аргуудад сургах, тухайлбал санхүүжилтийн гүйлгээ, групп доторх үйлчилгээ, хөрөнгийн шилжилт, эрдэс баялгийн экспортын бүтээгдэхүүнийг доогуур үнэлж байгаа зэрэг уул уурхайн салбарт ашиг шилжүүлж, татвараас зайлсхийх асуудлыг шийдвэрлэхэд чиглэх юм.

ЭЗХАХБ болон ЗГХФ нь татварын хууль эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах чиглэлээр Татварын ерөнхий газартай хамтран ажилласаар байна. Үүнд, тусгаарлах буюу ring-fencing журам зэрэг сэдвүүдээр чадавхийг бэхжүүлэх сургалт, семинар, түүнчлэн бусад эрэлт хэрэгцээг хангах техникийн зөвлөгөөнүүд багтаж байгаа. 2021 онд Монгол Улс нь дотоод болон ерөнхий үнэ шилжилтийн тайлан, жилийн ажил гүйлгээний үнэ шилжилтийн тайлангуудыг анх удаа хүлээн авсан. Эдгээр мэдээллийг үнэ шилжилтийн эрсдэлийг илрүүлэх,

үнэлэх зорилгоор үр дүнтэй ашиглах нь Татварын ерөнхий газрын нэн тэргүүний зорилт болоод байна. Тиймээс ЭЗХАХБ нь Татварын ерөнхий газрын эрсдэлийн удирдлагын газартай хамтран энэхүү мэдээллийг ашиглан татварын эрсдэлийг илрүүлэх тооцооллыг хийж тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна.

Эцэст нь ЭЗХАХБ нь Монгол Улсын хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох хүчин чармайлтын хүрээнд Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын Сангийн яаманд туслалцаа, дэмжлэгээ үзүүлсээр байна. Давхар татварын гэрээг урвуулан ашиглах асуудлыг шийдвэрлэх нь тус улсын нэн тэргүүний зорилт бөгөөд үүний тулд Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх Татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх олон талт конвенцод¹² (Олон талт хэрэглүүр буюу MLI гэгддэг) гарын үсэг зурж, соёрхон батлуулж, автоматаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

“ **Монгол Улсын Татварын алба нь өмнөх ололт амжилтуудаа бататгаж, үндэстэн дамнасан дэлхий даяарх татвараас зайлсхийхийн эсрэг тэмцэх олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, дотоодын орлого төвлөрүүлэлтийг дэмжиж, олон улсын түншүүдтэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх болно.** ”

Монгол улсын Татварын Ерөнхий газрын дарга
Батжаргалын Заяабал

ЭЗХАХБ нь Монгол Улсын татварын хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох замаар Татварын суурийг багасгаж, ашиг шилжүүлэхтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд нь Монгол Улсын Сангийн яаманд туслалцаа, дэмжлэгээ үзүүлсээр байна.



Тэмдэглэл

1. Дотоодын нийт бүтээгдэхүүн (2021) тайлан, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=GDP_2020Q4_en.pdf&ln=En. https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L14&type=tables, retrieved July 2021.
2. <https://www.ЭЗХАХБ.org/tax/beps/>.
3. <https://www.ЗГХФmining.org/>.
4. https://www.iisd.org/system/files/publications/mongolia-mining-policy-framework-assessment-en.pdf?utm_campaign=mongolia-mpf&utm_medium=post&utm_source=website-ЗГХФ.
5. <https://www.ЭЗХАХБ.org/tax/transparency/>.
6. <http://www.tiwb.org/>.
7. Үнэ шилжилт гэдэг нь Үндэстэн дамнасан корпорациуд группын доторх аж ахуйн нэгжүүдийн хоорондын ажил гүйлгээний үнийг тогтоосонтой холбоотой процесстэй холбоотой ойлголт юм. Сунгасан гарын зарчим гэдэг нь Үндэстэн дамнасан корпорациуд групп доторх ажил гүйлгээний татварын зорилгод болон татварын албанд хэрэглэх ёстой гэж ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын үзсэн олон улсын үнэ шилжилтийн стандарт юм. Дэлгэрэнгүй мэдээллийг ЭЗХАХБ (2017), ЭЗХАХБ-ийн Үндэстэн дамнасан корпорациуд болон татварын албаны үнэ шилжилтийн удирдамж 2017, ЭЗХАХБ Хэвлэл, Парис, <https://www.OECD.org/tax/transfer-pricing/OECD-transfer-pricing-guidelines-for-multinational-enterprises-and-tax-administrations-20769717.htm>.
8. <https://www.OECD.org/tax/tax-global/work-on-extractive-industries.htm>.
9. OECD /UNDP (2020), "Tax Inspectors Without Borders Annual Report 2020", <http://www.tiwb.org/resources/reports-case-studies/tax-inspectors-without-borders-annual-report-2020.htm>.
10. <https://www.OECD.org/ctp/exchange-of-tax-information/convention-on-mutual-administrative-assistance-in-tax-matters.htm>.
11. World Bank Group and World Mining Data
12. <https://www.OECD.org/tax/treaties/multilateral-convention-to-implement-tax-treaty-related-measures-to-prevent-beps.htm>.

Дэлгэрэнгүй мэдээллийг:



TaxandDevelopment@oecd.org



<https://oe.cd/tax4dev-studies>



@OECDtax #tax4dev



OECD Tax

Хариуцлага

Энэхүү бүтээлийг ЭЗХАХБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хариуцлагын дор хамтран хэвлүүлэв. Энд илэрхийлсэн санал бодол, үндэслэлүүд нь ЭЗХАХБ, Глобал форум болон тэдгэрийн гишүүн орнуудын засгийн газрын албан ёсны үзэл бодлыг илэрхийлэх албагүй юм.

Энэ баримт бичиг, түүнд орсон аливаа мэдээлэл, газрын зураг нь аливаа нутаг дэвсгэрийн статус, бүрэн эрхт байдал, олон улсын хил, хилийн заагийг тогтоолт, аливаа нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн нэрэнд харшлахгүй.

© ЭЗХАХБ 2022

Энэ бүтээлийг цахим, хэвлэмэлийн аль нэг хэлбэрээр нь ашиглах бол нөхцлийг дараах хаягаас авна уу www.OECD.org/termsandconditions.

Зурар © OECD and Shutterstock.com.